

ХИЛ СУДЛАЛЫН ҮНДЭС

Нэг. Хил судлал бол шинжлэх ухааны судалгааны бие даасан салбар мөн.

Хил судлал бол хаяа нийлэн орших улсуудын нутаг дэвсгэрийг зааглан тогтоосон улсын хил хязгаар нутаг дэвсгэрийн харилцан уялдаа холбоог судалдаг шинжлэх ухаан юм. Хил судлал нь шинжлэх ухааны судалгааны шинэхэн салбар болохыг НҮБ-аар хүлээн зөвшөөрөгдсөн, түүнийг албан ёсны гишүүн Олон Улсын Мэдээлэл Түгээхүйн Академи /МАН/ баталгаажуулсан билээ.

Ийнхүү хил болон хязгаар нутгийн тухай үзэл баримтлалд "Хил" гэдэг ойлголт чухал үүрэгтэй. "Хил" гэдгийг монгол хэлний тайлбар тольд "нутаг, газар орны хоорондын зааг" гэж тайлбарлаад тэрхүү зааг хэсгийг хамгаалдаг "Хилийн харуул" гэдгийг "хил хязгаарыг сэргийлэн суулгасан цэрэг" гэжээ. Хил гэдэг ойлголт нь материаллаг ертөнцийн харилцан уялдаа системийн чанарын тодорхой байдлыг тэмдэглэх бөгөөд эгэл болоод бичил ертөнцийн материаллаг талын тусгал болж байдаг. Хил гэдэг бол ямар нэгэн юмны төгсгөл, нөгөө зүйлийн эхлэл гэсэн санааг агуулж байна.

Юмс үзэгдэлд байдаг түгээмэл чанар нь хилийг философийн категор ухагдахуун гэж үзэх үндэс болж байна. Харамсалтай нь гүн ухааны толь бичгүүдэд "Хил" гэдэг ойлголтыг тайлбарлаж байсангүй. Харин И.Кантын "хилийн ойлголт", К.Ясперсийн "хилийн байдал" гэдэг нэр томьёо хэрэглэгдсээр иржээ. Эдгээр нэр томьёо нь хэлбэр болон агуулгаараа "хил" гэдэг ойлголтоос үүсэлтэй болох нь тодорхой байдаг.

Кантынхаар хилийн тухай ойлголт нь "танин мэдэхүйг хязгаарлахын зэрэгцээ хилийн нөгөө тал руу байгаа юмыг зааж тэмдэглэхгүй" гэжээ. К.Ясперс хилийн байдал гэдгийгээ нэг байдлаас нөгөөд шилжих бодит юмсын хөдөлгөөн гэж үзсэн байна. Тэрээр: "Бид хэзээ ямагт ямар нэгэн орон зайд оршино. Түүнийг өөрчлөхийн тулд би ажиллана. Гэхдээ би үхэх ёстой, би зовж шаналах ёстой, би тэмцэх ёстой, би тохиолдлын хүн, би буруутай болох гарцаагүй гэх мэт зүйл байнга л тохиож байдаг хилийн орон зай хэзээд байх ёстой. Хилийн орон зай бол гайхах эргэлзэхийн зэрэгцээ ухаарлын эх булаг болж байгаа юм. Бидний өвөрмөц ухамсрыг /өөрийн ухамсар/ сэргээн дагалдсан өнгөлөн далдлагдсан буюу цөхөрсөн хилийн тэр байдлыг бид мэдэрч байна" /Краткая Философская Энциклопедия" М.1994. с 347-348 гэж бичжээ.

Нийгмийн юмс үзэгдлээс бүрдсэн хил өвөрмөц онцлогтой. Хүмүүсийн ямар ч нэгдлийн оршин тогтнох материаллаг үндэс нь газар нутаг, хил хэмээн тэмдэглэсэн зааг хязгаар юм. Энэхүү хил хязгаар нутаг бол алив хүн буюу хуулийн этгээдэд хувийн өмчийн буюу аль эсвэл хэзээ нэгэн цагт хариуцуулж өгсөн газрын нэг хэсэг мөн. Энэ нь гэр бүл, хамт олон, засаг захиргааны нэгжид /баг, хороо, сум, аймаг/ хамааралтай.

Хүн төрөлхтөн үүсч буй болох явцад хүмүүсийн нийтлэгт /овог, угсаа/ нутаг дэвсгэрийг заагласан тодорхой хил хязгаар байсангүй. Тэд оршин амьдрах нөхцөл бүрдсэн газарт л байдаг байсан. Нутаг дэвсгэрийн хил гэж тэмдэглэх юм байсангүй, энэ нь хүмүүсийн бас өөр нэгдлийнхний байрлаж буй газар хүртэлх хэний ч биш зурвас газар байв.

Төр үүсэхтэй хамт хил бүхэл бүтэн, харьцангуй бие даасан тогтвортой шинж байдлыг олж улмаар газар нутгийг зааглан нэгтгэх явдал улс орны оршин тогтнох чухал нөхцөл болов. Ийнхүү хил бол улс түүний бүрэн эрхт байдлын зааг хязгаарыг тодорхойлох гол шинж болов. Тэрээр хууль эрхийн хэм хэмжээтэй болж, газар орон дээр тэмдэглэгдэж бас хамгаалагддаг болсон байна.

Улс орон ч газар нутаг, хил хязгаарт анхаардаг болж түүн дээр амьдарч буй хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалах болов.

Газар нутаг нэг улсаас нөгөөд шилжих, өөрөөр хэлбэл хилийн зааг өөрчлөгдөх явдал нь зөвсөгт мөргөлдөөнд хүргэж, олон хүний амь нас сүйдэх, зугтагсад, дүрвэгсдийг олноор буй болгоход хүргэдэг болов. Харамсалтай нь улсын хилийн өөрчлөлтийн уршгаар дээрх явдал өнөөгийн соёлт ертөнц дээр ч гарч байгааг бид харсаар байна. /хуучин ЗХУ-ын хилийн хуваагдал, Балканы хойгийн хямрал, Ойрхи Дорнодын үйл явдал г.м/

Улс гэдгийн хамгийн гол шинж болсон хил нь урт удаан хугацааны түүхтэй. Тэрээр олон улсын харилцаа, эрх зүй, гэрээ хэлэлцээрийг үүсгэж хөгжүүлэв. Өнөөдөр улсын хил нь зөвхөн хуурай газрыг зааглан тогтоосон шугамаар хязгаарлагдахгүй. Улмаар ус, газрын гүн, агаар мандлыг зааглан эзэмших явдлыг тодорхойлох зайлшгүй шаардлага гарч ирэв. Тиймээс Монгол Улсын Хилийн тухай хуульд: "Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараар зааглаж Монгол Улсын Олон улсын гэрээгээр тодорхойлж тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ. Уул шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас

эгц доош газрын хэвлийн хил байна" гэж хуульчилсан билээ.

Тийнхүү "хил" гэдэг ойлголтыг нь түүний түгээмэл агуулгын хүрээгээр философийн категори ухагдахуунд хамааруулж болох бөгөөд "улсын хил" /улс түүний хил/ гэдэг нэр томьёо нь нийгэм судлал, улс төр судлал, хууль эрх зүй, нийгмийн шинжлэх ухааны олон салбарт өргөн хэрэглэгдэж байна.

Хил судлалын шинжлэх ухааны судлах зүйлийг нь зөвхөн улсын хилийг зааглан тогтоосон шугамын асуудал биш, харин түүний чанарын тодорхой асуудал гэж ойлгох ёстой. Аль нэг хил хязгаарын зааг буюу төгсгөл, нөгөөгийн эхлэлийг тэмдэглэдэг хилийн шугам нь нарийн асуудал бөгөөд тэдгээрийн нэг нь нөгөөдөө нөлөөлж, харилцан үйлчлэлцэж байдаг.

Материаллаг биет бүхэн өөрийнхөө илч дулаан, гэрэл туяа, үнэрээр бусад биетэд нөлөөлж, өөрөө тэдгээрийн нөлөөний дор оршиж байдаг. Олонхи амьтад хүрээлэн буй орчинтойгоо харилцан үйлчлэлд орж өнгө төрхөө өөрчилж байдаг.

Байгалийн шинжлэлд материаллаг ертөнцийн юмсын харилцан үйлчлэлийн тухай талбайн онол гэж байдаг. Талбайн онолоор аль нэгэн жин /масса/ зохих хэмжээний хүчийг /энергия/ гаргадаг бөгөөд хүч нь жинг үүсгэдэг. Талбай нь нэг талаас материаллаг байдлаар нөгөө талаас тодорхой зай хэмжээнд оршиж буй ямар ч хүн, түүнд үйлчлэх нөлөө байж болохгүй материаллаг биетүүдийн харилцан үйлчлэлийн хэлбэр болж байна. дэлхийн таталцлын болон цахилгаан соронзон талбай, цөмийн хүчний талбай гэж бид өнөөдөр ярьж бичиж байгаа билээ.

Бие биеэс харилцан хамааралгүй объектуудын харилцан нөлөөлөл нь хэд хэдэн шалтгаанаас хамаарах бөгөөд эхний ээлжинд тэдгээрийн жин, шинж чанараас /таталцах, үнэр, цацраг гэх мэт/ тэдгээрийн хоорондын зай хэмжээнээс харилцан үйлчлэлцэж буй объектууд /агаар, ус, талбайн хүчдэл г.м/ байрлаж буй орчноос хамаарч байдаг. Харилцан хамааралтай буюу хамааралгүй систем /объектуудын/-ийн харилцан нөлөөлөл нь уг чанартаа тэдгээрийн харилцан нэвтрэлцэл болж байгаа хэрэг.

Объектуудыг хүний бие эрхтний чадавхийг өсгөх чадалтай хийх, харилцан ойлголцох, өөрөөр хэлбэл улс төр дипломатын болон орчин үеийн мэдээлэл судлахуйн аргаар шийдвэрлэхийг эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээ бидэнд олгож байна. Аль нэгэн газар нутаг эзэмшигчийн газрыг нөгөө эзэмшигчээс хүчээр авах замаар тэлж өргөжүүлж маргаантай асуудлыг шийдвэрлэж болохгүй. Ингэсэн тохиолдолд газар нутгийнхаа хэсгийг алдсан эзэн түүнийг эргүүлж

техник хэрэгслийн тусламжтайгаар батлан тогтоож болно. Тиймээс харааны багаж хэрэгсэл нь харааны эрхтнүүдийн сонсголын чадал боломжийг өсгөдөг бөгөөд соронзоны тусламжтайгаар хүний хараанд үл өртөхүйц далдлагдсан метал байгааг мэдэж болдог. Мөн дозиметрийн хэрэгслэлүүдээр радиацын хэмжээг тодорхойлох жишээтэй. Эдгээрээс үзэхэд материаллаг объектуудын хооронд хил судлалын судлах зүйл болох маш нарийн харилцан хамаарал бүхий харилцаа байна гэдэг дүгнэлтийг хийж болох байна.

Зааг хязгаар нь хилээр тэмдэглэгдсэн газар нутгийн эзэмшилд буй нийгмийн системүүдийн хоорондын харилцаа маш олон янз байдаг бөгөөд эх газрыг болоод гол, горхи, нуур цөөрмийг эзэмшигч тухайн улсын засаг захиргааны хоорондын харилцааны тухай энд өгүүлж байна. Эдгээр харилцаа нь эвсэг найрсаг байдлаас хүн төрөлхтнийг мөхөл сүйрэл рүү ойртуулсан бие биеийг дайсагнасан хэрэг явдал энэ орон зайнд илэрч байдаг билээ.

Өнгөрсөн үеүдэд болж байсан хурц зөрчлүүд газар нутгийг өмчлөх асуудлаас үүсч байсныг өмнөх үеийн сэтгэгчид тайлбарлаж байлаа. Энэ санааг Жан Жак Руссо /1712-1778/ "Тэгш бус байдлын шалтгааны тухай" гэсэн эрдэм шинжилгээний бүтээлдээ тусгасан байдаг. Тэрээр: "Нэгдүгээрт, хэсэг газрыг хашиж аваад л "энэ минийх" гэх бодол төрж, тэрээр үүнд итгэх сайн санаат хүмүүсийг олж, иргэний нийгмийг жинхэнэ үндэслэгч болсон. Хичнээн олон гэмт хэрэг, дайн байлдаан, аллага, хядлага, хичнээн олон үгүйрэл ядуурал, зовлонгоос хүн төрөлхтний өвөг дээдэс салсансан бол мөнөөх нутаг зааглаж хатгасан гадсыг сугалж, ухсан суваг шуудууг тэгшилж байсан хүн, "Газрын ашиг шим нь бид бүгдэд, харин газар нь хэнд ч хамаарахгүй гэдгийг мартахаа аваас та нар үхлээ гэсэн энэ зальт этгээдийг бүү сонсоорой" гэж ойр тойрныхондоо хашгирах байсан" гэж бичсэн нь бий. Тэр цааш нь бичихдээ: "Байнгын мөргөлдөөн аллагад хүргэсэн эцэс төгсгөлгүй тэмцэл газар нутгийг анх эзэмшигч хүчтэй эсэргүүцэгчдийн хооронд "эхэлсэн" гэжээ.

Үнэхээр газар шороо, нутаг дэвсгэрийн төлөө үүссэн тэмцэл гэмт үйлдэл, аллага, хядлага, дайн тулалдаанд хүргэсэн хүн төрөлхтний түүхэнд олонтаа тохиолдож байлаа. Хил хязгаараас үүдэн газар нутаг эзэмшигчдийн хооронд асар хүнд үр дагавар бүхий зөрчил тэмцэл өнгөрсөн үед ч болж байсан, өнөөдөр ч байсаар байна.

Гагцхүү хүн төрөлхтний түүх болон орчин үеийн бодит амьдрал, хил хязгаарын талаархи газар нутаг эзэмшигчдийн хоорондын маргааныг зөвхөн зэвсэг хэрэглэж хүчээр шийдвэрлэж болохгүй гэдэг дүгнэлт хийхэд хүргэж байна. Харин энэ маргааныг гэрээ хэлэлцээ

авахын төлөө тэмцэх нь гарцаагүй.

Хилийн харилцааны ихээхэн нарийн асуудал хил залгаа орших улсуудын хооронд байдаг. Олон тооны маргаантай асуудал үүсч зарим тохиолдолд хүнд үр дагавар бүхий зэвсэгт мөргөлдөөнд хүргэдэг явдал улсын хил хязгаар нутагт тохиолддог. Хөрш зэргэлдээх улстайгаа хиллэсэн хилийн маргаантай асуудал дэлхийн олон бүс нутагт олон жилийн турш байсаар ирэв. Энэхүү маргаантай асуудал нь хил залгаа аль нэг улсын нутаг дэвсгэрийн хэсэг урьд өмнө нь хэнийх нь байснаас болж үүсдэг. Жишээлбэл Өмнөд Курилын арлууд урьд өмнө нь хэнд хамаарч байсан талаар ОХУ, Японы хооронд үүссэн маргаан, үүний зэрэгцээ манай орны хувьд ч ОХУ болон Хятадын нутагт орчихсон гэсэн яриа өгүүлэл байдаг нь дээрхийг нотолж байна.

Зэргэлдээх улсдаа газар нутгийн маргаантай асуудлыг тавьж буй улс орон уг газар нутгийн хэсэг урьд өмнө хэний эзэмшилд байсныг хөндөж тухайлбал газар нутгийн энэ хэсэг байлдаан тулалдаанаар алдагдсан, эсвэл худалдагдсан, бас түр эзэмшигдэж байсан гэх мэт шалтгаанаар маргаантай асуудлыг үүсгэдэг. Газар нутаг, хил хязгаарын маргаантай асуудал хурцдах буюу зөөлрөх нь улс хоорондын харилцаанд байнга гарч байдаг. Хил хязгаарын тухай энэ асуудал дэлхийн нийтийн хамтлаг болон улс орон тус бүрд нэн чухал. Эдгээр асуудлын зарим нь НҮБ-аар, өөр нэг хэсэг нь хил залгаа орших улсуудын хооронд хилийн асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулах замаар шийдвэрлэгддэг. Хил судлалын шинжлэх ухааны судлах зүйл нь эдгээр асуудлууд юм.

Туурга тусгаар улсуудын харилцааны хүрээнд багтаж буй нэн чухал асуудлын тоонд ард түмэн үндэсний тусгаар тогтнолоо тогтоох эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байх зэрэг олон улсын эрх зүйн чухал зарчмууд багтаж байгаа юм. Гэтэл олон улсын эрх зүйн нэн чухал зарчмуудыг сөрсөн асуудлууд үүсч хүчтэй маргаан зэвсэгт тулгаралт /Нагорный Карабах, Абхаз, Чечень, Балканы хойг, Ойрхи Дорнодын болон бусад хэрэг явдлууд/ болж байсныг бид мэдэж байна. Олон улсын эрх зүйн дээр дурдсан зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэх явцад зэвсэгт мөргөлдөөнүүдийг таслан зогсоох явдлыг судалж шийдвэрлэх асуудал чухлаар шаардагдаж байна. Түүнчлэн дээрх асуудлыг судлахад усан болон агаар мандлын хилийг хамгаалах тэдгээрт болж буй ноцтой асуудлыг зохицуулах хязгаарлах явдал чухал болж байна.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн нийгэм, улс төр болон эдийн засгийн бодит байдлыг харгалзан Олон Улсын Мэдээлэл Түгээхүйн Академи /МАИ/ хил судлалыг шинжлэх ухааны шинэ салбар гэдгийг

хүлээн зөвшөөрч, хил судлалын салбаруудыг улс орон бүрд байгуулж улсын хил хязгаар нутагтай холбоотой асуудлыг судлах хэрэглээний болоод хавсарга судалгааны зорилтыг шийдвэрлэхэд үйл ажиллагааг нь чиглүүлж байгаа билээ.

Монгол орны нөхцөлд хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх зорилгын үүднээс Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг-төрийн бус байгууллагын хэлбэрээр байгуулагдсан юм. Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэгт шинжлэх ухааны олон салбарын төлөөлөгчид, хуульчид, эдийн засагчид, түүхчид, математикчид, цэргийн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачид, төр олон нийт, аж ахуйн байгууллагынхан хязгаар нутагт амьдарч хөдөлмөрлөж буй хилийн цэрэгт туслах хүчнийхэн, хилчид нэгдээд байгаа билээ.

Тус нийгэмлэгийн үйл ажиллагаа нь:

- ❖ эрдэм шинжилгээ-судалгааны,
- ❖ мэдээлэл судлал-сурталчилгааны,
- ❖ хил хамгаалалт-практик үйл ажиллагааны гэсэн чиглэлээр явагдаж байгаа бөгөөд эрдэм шинжилгээ судалгааны асуудал эрхэлсэн хэсэг нь Монгол Улсын хил, хязгаар нутгийн өнөөгийн тулгамдсан асуудлыг судалж, оношлох, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход гол анхаарлаа чиглүүлж байна. Хил судлал нь шинжлэх ухааны харьцангуй шинэ салбар мөнийн хувьд нийгэм, төр засаг-бие хүний ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа хязгаар нутагт хэрхэн явагдаж байгаа болоод тэдгээрийн шинж чанар, зүй тогтлыг судалдаг юм.

Нийгэмлэгийн нэр хүнд бол Монгол Улсын хил, хилчдийн нэр хүнд бөгөөд эдүгээ дотоод, гадаадад өсөх магадлал ихтэй болов. Үүний нэг тод жишээ нь 2000 оны 11 дүгээр сард НҮБ-д зөвлөлдөх эрх бүхий Олон Улсын Мэдээлэл Түгээхүйн Академиас зохион байгуулсан Бүх дэлхийн мэдээлэл судлалын Чуулган Москва хотноо болж энэ арга хэмжээнд дэлхийн 60 гаруй орны 5700 гаруй төлөөлөгч оролцож "XXI зуунд хүн төрөлхтний мэдээлэл судлахуйн тулгамдсан асуудал" гэсэн сэдэв хэлэлцсэн бөгөөд дэлхийн хэмжээний энэ том арга хэмжээнд Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн доктор /Ph/ дэд профессор, хошууч генерал П.Даш, тус нийгэмлэгийн гишүүн хурандаа Х.Лхагвасүрэн нар оролцож, генерал П.Даш, дэлхийн тэр чуулганы тэргүүлэгчдийн байранд залагдаж Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэгийг төлөөлж үг хэлсэн явдал юм.

Монгол Улсад Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байгааг дэлхийн энэ том

чуулганд оролцогсод талархан хүлээн авч улмаар НҮБ-д, Зөвлөлдөн эрх бүхий Олон Улсын мэдээлэл түгээхүйн академид хил судлалын Монголын салбарыг гишүүнээр элсэхийг санал нэгтэй дэмжсэн байна.

Олон Улсын Мэдээлэл Түгээхүйн Академийн хил судлалын Монголын салбарыг байгуулах явдал нь нийгэм, төр, хувь хүний ашиг сонирхолын харилцан нэвтрэлцэх, харилцан хүрээнд хил болоод хязгаар нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх замаар дэлхий нийтийн мэдээллийн нэгдсэн орон зайд багтах улмаар хамтарч ажиллах аятай нөхцөл бүрдэх болно. Ийм нөхцөлд хил судлал нь хилийн талаар явуулах төрийн бодлогын шинжлэх ухааны үндэс болж байгаа юм.

Хил судлалын шинжлэх ухааныг агуулгын талаас нь авч үзвэл:

- ❖ улсын хил, түүний хамгаалалтын түүхийг судлах
- ❖ төрөөс хилийн талаар явуулах бодлогын онол
- ❖ арга зүй, хууль эрхийн үндсийг боловсруулах
- ❖ Монгол Улсын хилийг сэргийлэн хамгаалах онолыг хөгжүүлэх чиглэлтэй гэж хэлж болно.

Монгол Улсын хил болоод хязгаар нутгийн тулгамдсан асуудал нь улс төр, эдийн засаг, цэргийн болон бусад асуудалтай салшгүй холбоотой юм. Тэдгээрийн дотроос Монгол Улсын хил болон хязгаар нутагтай шууд хамаарал бүхий дөрвөн асуудлыг онцолж авч үзэж болох байна. Энэ нь:

Нэгдүгээрт: Монгол Улсын хилийн эрх зүйн үндсийг тодорхойлох

Хоёрдугаарт: Улсын хилээр дамжин өнгөрөх хүн, ачаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нарийн зохицуулах

Гуравдугаарт: Улсын хилийг сэргийлэн хамгаалах

Дөрөвдүгээрт: Төрөөс хилийн талаар явуулах бодлогын субъектуудийн /ГХЯ, БХЯ, УАБХГ, ХЗДХЯ, УГЕГ болон бусад/үйл ажиллагааг нягт уялдуулан зохицуулах явдал мөн. Сүүлийн үед хил судлалд анхаарвал зохих шинэ асуудал үүсч байгаа бөгөөд энэ нь тусгай судалгааг шаардаж буй үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэг, хилийн дагуух гол мөрөн нуурын болон хил орчмын ойн экологийн нөөцийг хамгаалах зэрэг асуудал болоод байна. Монгол Улсын хил дээр шийдвэрлэгдэж буй практик асуудлууд нь хүн төрөлхтний хөгжлийн хоёр хандлагыг тусган харуулж байна. Үүнд:

Нэгдүгээрт. Хүмүүс болон хүмүүсийн нийтлэг, улс орны эрмэлзэл нь орчин үеийн дэлхийчлэлийн асуудлуудыг хамтарч шийдвэрлэх гэсэн цул нэгдмэл хандлага болов. Энэ нь хилийг аливаа улс орныг олон улсын хамтын нийгэмлэгээс тусгаарласан"төмөр

хөшиг”болгохгүй байхыг хэлж байна.

Хоёрдугаарт. Хүмүүс болон хүмүүсийн нийтлэг, улс орны эрмэлзэл нь тусгаар тогтнол, бие даасан халдашгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн хандлага бөгөөд энэ нь нэгдэх хандлагын адил зүй тогтолт үйл явц болов. Нэг талаас улсын хилийг хамгаалах хэрэгтэй боловч нөгөө талаас тэрхүү хамгаалалт нь хүмүүс болон хүмүүсийн нийтлэг, улс орны дэлхийн хамтын нийгэмлэгээс тусгаарлах үйл ажиллагааг нь хязгаарлах буюу зогсоон барих механизм байж болохгүй.

Ийм учраас улсын хилийн болон хязгаар нутгийн асуудал нь өөрийнхөө цар хүрээ, ач холбогдлоор тусгай судалгааг шаарддаг болохыг дээрх асуудал нотлон харуулж байна. Улс орон бүр, дэлхийн хамтын нийгэмлэг бүхэлдээ үүнд хамаарах ёстой.

Хил судлал нь шинжлэх ухааны судалгааны салбаруудын нэгэн адил өөрийн категориудтай. Эдгээрээс түгээмэл хэрэглэгддэг, категори, нэр томъёонууд гэвэл “Хил”, “Улсын хил”, “төрийн хилийн бодлого”, “хязгаар нутаг” “хилийн дэглэм”, “улсын хилийн хамгаалалт”, “хилийн хяналт”, “гаалийн хяналт” гэх мэтийг үүнд хамруулж болно. Эдгээрийн тус бүрд нь улс орны болоод дэлхийн хамтын нийгэмлэгийн амьдралын чухал асуудлууд тусгалаа олж байдаг юм.

Шинжлэх ухааны аль ч салбарын нэгэн адил хил судлал нь ажиглалт, туршилт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, түүхэн болоод учир шалтгааны, индукци, дедукцын систем, дүн шинжилгээний, математик загварчлалын гэх мэт шинжлэх ухааны ерөнхий арга болон танин мэдэхүйн тусгай аргуудтай байдаг. Дадлага сургууль, тусгай операци явуулж, тэдгээрийн явцад онолын асуудлуудыг судалж боловсруулах, мөн үүнтэй нэгэн зэрэг практик зорилтуудыг шийдвэрлэх тусгай аргууд үүнд хамаардаг.

2000 оны 4 дүгээр сэрд байгуулагдсан Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг үйл ажиллагааныхаа эхний алхамуудыг хийж байна. Нийгэмлэгийн зарим гишүүд тухайлбал доктор /Ph/ профессор Ш.Арвай “Монгол Улсын хил хамгаалалтад үзүүлэх хүчин зүйлсийн нөлөөлөл, цаашдын төлөв” сэдвээр ХЦУГ-ын захиалгаар төсөл хийж дуусгасан. Доктор /Ph/ профессор А.Муратхан “Диссертаци боловсруулах арга зүйн зөвлөмж”, хошууч генерал Я.Пүрэвдорж, дэд хурандаа Д.Нямдорж нар “Даргын шаардлагын сурган хүмүүжүүлэх ухаан”, Ц.Ганболд “Монгол Улсын хилийн төлөөлөгч”, Г.Дагважамц “XXI зууны Азийн талаарх төсөөлөл, нөлөөлж буй хүчин зүйл”, “Монгол-Оросын харилцааны зарим асуудал”, “Монгол улсын оршин тогтнохын баталгаа, хөрш гүрнүүдийн

харилцааны зарим асуудал" , "Монгол-Оросын хилийн харилцааны асуудалд", Ч.Дашдэлэг "Улсын хил хамгаалалтын өнгөлөн далдлалт", тус нийгэмлэгийн гишүүн асан дэд доктор А.Осор "Улсын хил хамгаалалтад албаны амьтдыг ашиглах нь" зэрэг ганц сэдэвт зохиол, фондын лекцүүдийг хэвлүүлж "Хил судлал" сэтгүүлийн зургаан дугаарыг гаргаж уншигчиддаа хүргэсэн юм.

ХОЁР. Хил судлалын судлах зүйл, судалгааны зорилт.

Өнгөрөгч зууны 90-ээд оныг хүртэл бид дэлхий ертөнц дээр болж буй үйл явдлыг үнэн зөв үнэлж дүгнэж цэгнэж явсангүй. "Хүйтэн дайн" гэгч төгсгөл болно, хүчирхэг ЗХУ тарж бутарна, дэлхийн хувь заяаг шийдэх хоёр том хуваагдал цагийн эрхээр үгүй болно гэж огт бодоогүй явлаа. Олон улсын гэрээ хэлэлцээрээр баталгаажсан тодорхой тогтвортой хил газар нутаг, эрх зүйн хувьд баталгаагүй болчих чинээ ч санаагүй. Дэлхийн хоёр эвслийн хоорондын харилцааг тодорхойлж байсан бүх нийтийн аюулгүй байдлын асуудалд өмнө нь төвлөрч байсан улс төрийн болоод цэргийн шинжлэх ухаан өнөөдөр бүх нийтийн болон бүс нутгийн аюулгүй байдалд хэрхэн холбогдох вэ? асар хүчтэй /цэрэг-улс төрийн/ бас эмзэг нарийн /хилийн / нийгэм соёлын болон геободлогын нэгдмэл талбарыг үүсгэх харилцан хамаарал хэрхэн буй болох вэ? гэдэг асуултад хариу өгөхөд бэлэн бус байна. эрч хүчээ авсан эдийн засаг-нийгмийн болон нийгэм-улс төрийн үйл явц урьд өмнө нь хуримтлагдсан туршлага, уламжлалт арга хэрэгслүүдийг ашиглах үндсэн дээр төр, засаг, нийгэм, бие хүний ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй байгаа өнөө үед дээрх харилцаа уялдаа онцгой ач холбогдолтой болж байна.

Нийгэм-төрийн өмнө дэвшигдсэн мэдлэгийг төлөвшүүлэх, тэдгээрийн харилцан хамаарлыг буй болгох үүднээс энэ үзэгдлийг ойлгож цэгцлэх онолын сэтгэлгээний хэрэгцээ аяндаа гарч ирлээ. Энэхүү хэрэгцээ шаардлага нь хил болон хязгаар нутгийн тухай иж бүрэн шинжлэх ухаан болох хил судлалыг хөгжүүлэх замаар биелэлээ олох учиртай.

Шинжлэх ухаан бүр судлах зүйл, судалгааны объекттай байдаг.

"Хил судлал" гэдэг нэр бол бодит байдлын чухам ямар салбарыг судлах вэ гэдгийг ямар нэгэн хэмжээгээр тусгаж байгаа болохоос тухайн шинжлэх ухааны объект болон судлах зүйлийг тодорхойлохгүй.

Аль ч систем түүний дотор нийгмийн системийн тодорхой хэмжээгээр томьёологдсон, зохион байгуулагдсан байх ёстой бөгөөд өөрийгөө зохион байгуулах, хамгаалах механизмтай холбоо бүхий асуудлыг ямар нэг хэмжээгээр агуулсан байдаг. Энэ нь бидний энд авч үзсэн системд зааг хязгаар байгааг харуулж байна. Эсрэг тохиолдолд энэ системийг хүрээлж буй орчин түүнээс салгаж болохгүй, түүнтэй харилцан хамааралтай байх учиртай. Энэхүү систем, хүрээлэн буй орчингийн хоорондох зааг хязгаар нь энэхүү системийн бүрэн бүтэн байдал, ангид тусдаа чанар, түүний ил болон далд байдлын хэмжээ далайц, бас энэхүү системийн удирдлагыг төвлөрүүлэхэд шаардагдах хэм хэмжээг тодорхойлдог байна.

Ийнхүү улс гэж ойлгож болох байгаль-нийгмийн систем нь байгалийн болоод хүн амын нөөц бүхий тодорхой газар нутаг болох бөгөөд тодорхой зааг хязгаартай байдаг. Улс гэдгийн орон зай цаг хугацааны шинж чанар нь тодорхой дэвсгэр нутаг дээр тодорхой орон зайд орших байдлаар тодорхойлогдоно. Энэ үзэл санаа нь нилээд хугацааны турш хил, хязгаар нутаг дэвсгэрийн заагаар хязгаарлагдаж байсан билээ. Улс гэдэг нь газар нутаг, хүн ам, засаг захиргаа бүхий элементүүдээс бүрдэх улс төрийн нийлмэл цогц юм. Газар нутаг гэдэг нь улсын орших орон зайг бүрдүүлэх бодит үндэс мөн. Энэхүү бодит үндэс нь улс орны оршин амьдрах бололцоог буй болгогч нэг нөхцөл болж байдаг. Эцсийн эцэст газар нутаг цаг үеэ дагаж өөрчлөгдөж байдаг хэдий ч газар нутаггүйгээр улс орон оршин тогтнодоггүй. Газар нутаг бол түүн дээр буй хүн ам бүхий улсын оршин амьдрах орон зай, эрх зүйн орчин хэм хэмжээгээр тодорхойлогдон хэрэгжиж буй улс төрийн элитийн засаглал үйлчилж байгаа хэрэг. Өөр улс гүрэнд бус өөрийнхөө ард түмэнд үйлчилж буй нийгмийн гол зорилгын нэг нь улс орны газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах явдал юм. Үүнээс гадна, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах явдал нь улс тус бүрийн хилийг нарийн нягт тодотгосон, түүнийг олон улсын эрх зүйн баримт бичиг, гэрээ хэлэлцээрээр баталгаажуулж байхыг шаарддаг.

Улс орон үүсэх, үгүй болох асуудал юуны өмнө газар нутагтай салшгүй холбоотой бөгөөд түүний газар нутгийн бүрэн бүтэн, халдашгүй байдал нь үүдэн гарах маргаан зөрчилдөөний хамгийн хурц асуудал болдгоор тайлбарлагдана.

Иймээс ч ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр гарын үсэг зурсан "Улаанбаатарын тунхаглал"-д /2000 он/ "Монгол Улс, ОХУ-ын хоорондын улсын хилийн шугамыг ялангуяа хил орчмын хүн амын аж ахуйн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж буй газруудад улам нарийн тодорхой зааж тогтоох зорилгоор улсын хилийг шалгах Монгол,

Оросын хамтарсан комиссоос гүйцэтгэн дуусгаж буй ажил ихээхэн ач холбогдолтой гэж Монгол-Орос хоёр улс үзэж байна" гэж цохон тэмдэглэсэн нь улс гүрний газар нутгийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг сахих, үүсч болзошгүй маргаантэй асуудал зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн ач холбогдлыг илтгэн харуулж байна.

Улсын газар нутагт эх газар, газрын хэвлийн болон агаар мандлын хил, усан хил тус тус багтдаг. Энэ нь улс гүрэн энд дурдсан орчинд бие даасан засаглалыг тогтоож, бусад улс орны болон хувь хүний халдлагаас тэдгээрийг хамгаалах эрхтэй гэсэн үг юм.

Ийнхүү харьцангуй тогтвортой, газар нутгийн бүрэн бүтэн байдал баталгаатай байх явдал улс орныг сахин хадгалах чухал нөхцөл болдог байна. Иймээс улс орны материаллаг үндэс болсон газар нутгийг хянах асуудлын эргэн тойронд дотоод, гадаад олон тооны зөрчил маргааныг шийдвэрлэх гадаад /зэргэлдээх/ улс орнуудтайгаа тогтоосон харилцааг зохицуулах үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс дипломат харилцааг тогтоож явуулах хариуцлагыг төр засаг хүлээдэг байна. Хил дээр тогтоосон дэглэм журмыг сахиулах, үндэсний аюулгүй байдлыг хангах, олон улсын энэ асуудлыг ололт дутагдлаас хамаарч засаглалаа бэхжүүлэх, сулруулж алдах асуудлыг шийдвэрлэх ёстой. Улс төрийн засаглал мөн чанараа хадгалахын тулд дэлхийн хамтын нийгэмлэгт улс орныхоо бүрэн бүтэн халдашгүй байдлыг хадгалах, түүний ашиг сонирхлыг улсын хил болон хязгаар нутагт хамгаалахын төлөө тэмцэх ёстой.

Улс төрийн амьдралын олон талт үйл ажиллагаа нь дэлхий ертөнц дээр түүний орших хүрээг буй болгодог. Энэхүү хүрээнд улс орны, бүс нутгийн, дэлхийн гэсэн байдаг. Энэ сэдвийн хүрээнд улсын хил дээр амьдралын тэр хэсгийг авч үзэх агаад хилийн амьдралын хүрээ гэж нэрлэсэнтэй ойртуулж ойлгох ёстой. Хилийн амьдралын хүрээ гэдэг нь үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдал, бүрэн бүтэн байдал зэрэг үнэт зүйлст захирагдах хил болоод хязгаар нутгийн холбогдол бүхий юмс үзэгдэл илэрч байдаг улс төрийн амьдралын нэг хэсэг юм. Хилийн амьдралын хүрээнд засаг захиргаа, түүний институт дэх засаг төрийн үйл ажиллагааны бүхэл бүтэн цогц хэрэгждэг бөгөөд түүнчлэн ашиг сонирхлоо хамгаалах зэргэлдээх /хил залгаа/ улсуудтайгаа харилцах харилцаанд хэрэгцээ шаардлагаа хангахад нийгэм, хүн амын тодорхой бүлэг ба хүний үйл ажиллагааг зохицуулахад зориулагдсан хилийн талаар явуулах бодлого хэрэгжих ёстой.

Хилийн амьдралын хүрээний материаллаг үндэс нь хязгаар нутаг юм. Үүнтэй холбогдуулан өгүүлэхэд өнөөгийн ОХУ-ын хилийн

холбогдолтой ном, товхимол тэдгээрт нийтлэгдсэн өгүүлгүүдэд "Пограничные пространства" гэсэн үг олонтаа тааралдах бөгөөд түүнийг манайхан "хилийн орон зай" гэж үгчлэн орчуулж хэрэглэсээр байгаа билээ. Тухайлбал, хил судлаач эрдэмтэн Ш.Арвай өөрийн хийсэн төсөл, бичиж туурвисан бүтээлүүддээ дээрхийг "хилийн орон зай" гэж орчуулж хэрэглэсэн бөгөөд энэхүү "орон зай" гэдэгт улсын хилийн шугамаас нутгийн гүн рүү 200 км хүртэлх үргэлжлэх хэсгийг хамааруулна гэж тайлбарласан байдаг. Үүнд манай улсын хилийн дагууд оршиж буй 14 аймаг, 67 сумын нутаг хамаарч байгаа юм.

Миний ойлгож байгаагаар "хилийн орон зай" гэдгийн оронд манайд эрт дээр үеэс уламжлан хэрэглэгдэж ирсэн "хязгаар" гэдэг үг бий бөгөөд энэ нь "хилийн орон зай" гэдэг ойлголттой утга агуулгын хувьд яг дүйж байгаа тул хязгаар нутаг гэдэг үгийг хэрэглэх нь зүйтэй гэж үздэг. Бид саяхан болтол "хязгаарын цэрэг", "хил хязгаар", "хязгаарын ба дотоодын цэрэг" гэж ярьж бичиж байсан шүү дээ. Иймээс хязгаар нутаг гэдэг бол улсын хилийн дагуу орших улс орны дотоодод хил болон хязгаар нутагтай холбоо бүхий юмс үзэгдлүүд өрнөн явагдаж байдаг тодорхой пунктүүд /хилийн хяналтын болон гааль, ариун цэвэр, хорио цээрийн болон бусад/ зэргийг хамрах нийгэм-геободлогын орчин гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, хязгаар нутаг гэдэг нь улс хоорондын хилийг заагласан хилээр дамжин харилцан нэвтрэлцэх болон харилцан нөлөөлөх, харилцан үйлчлэлцэх үйл явц явагдаж байдаг зааг хязгаар, зэргэлдээх улсуудтай хил нийлсэн хэсэг нийгэм-улс төрийн онцгой бүс нутаг юм.

Тийнхүү аливаа улс орны аюулгүй байдлыг шууд тодорхойлж буй улс төр, эдийн засаг, цэрэг, нийгмийн ашиг сонирхлын /үндэсний/ олон асуудал улсын хил, хязгаар нутагт өрнөж байгаа билээ. Орон нутгийн шинж чанартай дайн, хөрш зэргэлдээх улсаас үйлдэж болзошгүй тагнан турших-өдөөн хатгах үйл ажиллагаа, газар нутгийн маргаан, зэр зэвсгийн хууль бус наймаа, контрбанд болон хар тамхины панз, хүн амын хууль бус суурьшилт, байгаль орчны бохирдолт, түүний нөөцийг цөлмөн түйвээх ажиллагаа зэрэг олон асуудлууд нь хил судлалын судлах зүйл болж байгаа юм.

Эндээс дүгнэлт хийвэл, хил судлалын шинжлэх ухааны объект нь улсын хил болон хязгаар нутаг бөгөөд түүний судлах зүйл нь хил болон хязгаар нутагт өрнөж буй юмс үзэгдлийн зүй тогтол, хилийн амьдралын хүрээнд хамаарах асуудлууд юм.

Бүх шинжлэх ухааны онолын нэгэн адил хил судлал нь дараах элементүүдийг өөртөө агуулсан дотоод бүтэцтэй байдаг. Энэ нь

*Хил судлалын түүхэн үндэслэл /тухайн шинжлэх ухааны онол, зарчим, асуудал, дотоод мөн чанарыг боловсруулсан түүх/

*Хил судлалын эмпирик үндэслэл /тухайн шинжлэх ухаан тулгуурлаж байдаг шинжилгээ судалгааны баримтуудын цогц хуримтлал/

*Хил судлалын нийтлэг үндэслэл /шинжилгээ судалгааны баримтуудыг нэгтгэн дүгнэх, нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн ажлын хүрээнд асуудлыг судалж дүгнэх/

*Хил судлалын учир шалтгааны бодит үндэслэл /сэтгэхүй, учир шалтгааны тухай ойлголт, сэтгэлгээ, нотолгоо, хууль зүй, хуулийн нийлбэр цогц/

*Хил судлалын арга зүйн философи үндэслэл /мэдлэгийн онолын систем суурилж байдаг арга зүй, ертөнцийг үзэх үзлийн болон нийгмийн зарчмууд/

*Хил судлалын хэрэглээний үндэслэл /төрийн хилийн бодлогыг тодорхойлсон хамгийн чухал, үндэслэлтэй байх чанар, хил болон хязгаар нутгийн хамгаалалтын цэрэг техникийн асуудал гэх мэт/

Хил судлал нь төрийн хилийн бодлогын онол, хил хамгаалалтын стратегийн онол, гаалийн хамгаалалтын онол гэх мэт хэд хэдэн бие даасан чиглэлүүдийг багтаасан иж бүрэн шинжлэх ухаан юм. Хэрэв эдгээр чиглэлүүдийн шалгуур болгож хязгаар нутагт учирч болох халдлагыг авч үзэхэд хил судлал нь цэрэг, эдийн засаг болон хүнсний, технологийн, мэдээллийн, хүрээлэн байгаа орчны, шинжлэх ухааны, валют, санхүүгийн аюулгүй байдлын салбарт судалгаа явуулах болно. Иймээс хил судлал нь шинжлэх ухааны бие даасан салбар мөнийн хувьд нийгмийн шинжлэх ухааны /гүн ухаан, улс төр судлал, нийгэм судлал, эдийн засгийн онол, түүх, боловсрол судлал, сэтгэл судлал, хууль зүй гэх мэт/ байгалийн ухааны /математик, газар зүй, эколог, анагаах ухаан, биологи гэх мэт/, цэргийн шинжлэх ухааны /тактик, оперативын урлаг, цэргийн удирдлагын онол, цэргийн байр зүй гэх мэт/, техникийн /кибернетик, мэдээллийн онол, мэдээлэл судлал гэх мэт/ шинжлэх ухаануудтай нягт холбоотойгоор хөгждөг. Жишээлбэл, нийгэм-төрийн байгуулалтын болон улсын эрх зүйн асуудлыг судалдаг шинжлэх ухаан гэхэд л төрийн байгуулалтын үндэс болон зэргэлдээх улс орнуудын олон улсын статусын тухай, нутаг дэвсгэр, хил хязгаарын тухай, улс орнууд болоод бүс нутгийн олон улсын эрх зүйн тухай мэдээллээр хил судлалыг баяжуулж байдаг.

Хил судлалын шинжлэх ухааны өвөрмөц нэг онцлог нь бусад

шинжлэх ухаануудын ололтын үндсэн дээр хил болон хязгаар нутагт өрнөж буй байгаль, нийгмийн үзэгдлийн зүй тогтол, чиг хандлага, мөн чанарын онцлогийг тусгаж улс орны үндэсний аюулгүй байдал, түүний ашиг сонирхлыг хил болон хязгаар нутагт хамгаалахад нөлөөлөх улс төр, эдийн засаг, цэргийн болон байгаль цаг уур, газар зүй мэдээллийн хүчин зүйлийг зөв үнэлэх явдал юм.

Хил судлал нь шинжлэх ухааны танин мэдэхүйд гурван үндсэн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь:

1. Судалгааны объект, судлах зүйлийнхээ бодит чанар, харилцан уялдаа, чиг хандлагыг илрүүлэх зорилгоор зөвхөн шинжилж, нэгтгэн дүгнэж, жишиж харьцуулсны үндсэн дээр онолын чанартай үзэл баримтлал гаргах

2. Судалгааны объектын гол шинжийг тодорхойлж буй зүйлүүдийн холбоо, харилцан хамаарлыг тогтоож, түүний зүй тогтлыг нээн илрүүлэх замаар юмс үзэгдлийн мөн чанарыг илрүүлж, тайлбарлах,

3. Юмс үзэгдлийн эцсийн үр дүнд хамаарах тооны болоод чанарын үнэлгээгээр судалгааны объект, судлах зүйлд нөлөөлж болзошгүй асуудлыг нээн илрүүлж урьдчилан хэлж өгөх зэрэг болно.

Эдгээр үүргийг хэрэгжүүлэхдээ, Монгол Улс, тусгаар улсуудын хамтын нөхөрлөл, ОХУ, Хятад, Ази Номхон далайн бүс нутаг, Зүүн хойд Ази гэх мэт орон зай цаг хугацааны урьтсан байдлыг харгалзан үздэг байна. Ийнхүү учир шалтгааны үүднээс суурь судалгааны үндсэн дээр судалгаа явуулахад зориулагдсан хил судлалыг хэрэглээний талаас авч үзэх нь чухал болохыг тэмдэглэх хэрэгтэй.

*МХСҮН-ийн тэргүүн
Г.Дагважамц.*

